



ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ
ᠬᠡᠯᠲᠡᠰ

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020/03



sukhbaatar.nso.mn

www.1212.mn



Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг 1212.mn аппликейшнаар дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ ?

 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн нэгдсэн сан

www.sukhbaatar.nso.mn

Сүхбаатар аймгийн статистик хэлтсийн вэб хуудас

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДЭСЭН САН



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ** бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail хаягаа бүртгүүлснээр статистикийн мэдээллийг цаг алдалгүй тогтмол авч байх болно.

SOCIAL NETWORK



www.facebook.com/Статистик-Мэдээлэл



www.twitter.com/statistic_mn

СҮХБААТАР АЙМАГ



www.facebook.com/statistic



Утсаар:



Лавлах утас
1900-1212

Сүхбаатар аймаг
7051-8203



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**3 сар
2020**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-15
Үндсэн үзүүлэлтүүд	16

I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хөдөлмөр	17-19
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	20-21
I.3 Эрүүл мэнд	22-23
I.4 Соёл, урлаг	24
I.5 Газар өмчлөл	25
I.6 Гэмт хэрэг	26-27

II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	28
II.2 Төрийн санхүү	29-30
II.3 Үнэ	31-32
II.4 Хөдөө аж ахуй	33-36
II.5 Аж үйлдвэр	37-39



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-III, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0	Маш бага тоо	+, -	Зөрүү
-	Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 20-19 нь 2020 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөөг, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөгч:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг
- Хүний эрүүл мэндэд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Олон нийтийн аюулшүй байдлын ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.



- **Мөнгө, банк, даатгал:** Монгол улсын Төрийн болон албаны нууцын тухай хуулиар байгууллагын нууцын жагсаалтанд орсон учир Монгол банкны нэгдсэн дүнгээр гаргав.
- **Даатгал:** Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2015 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2020 оны 3 дугаар сарын байдлаар)


I. Нийгмийн үзүүлэлт



I.1. Хүн ам

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2020 оны эхний 3 сард 327 хүүхэд шинээр мэндэлж, 103 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 224 болж өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар буюу 31-ээр өссөн.

Зураг.I.1.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны эхний 3 сард



I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 3 сарын эцэст 914 болсны 439 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 687 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оноос 3.3 хувь буюу 22 хүнээр өсчээ.

Эхний 1 улирлын байдлаар хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 470 иргэн шинээр бүртгүүлсний 109 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг I.2.1 Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, жил бүрийн 3 сарын байдлаар





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 53.0 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 15.1 хувь нь бакалаврын дээд, 3.1 хувь нь тусгай дунд, 7.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 51.4 хувь нь бүрэн дунд, 15.4 хувь нь суурь, 4.9 хувь нь бага боловсролтой, 2.9 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг I.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, эхний 3 сарын байдлаар



Эхний 3 сарын байдлаар 67 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оны мөн үеэс 19.6 хувь буюу 11-ээр өсчээ. Шинэ ажлын байрыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл: төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 30 буюу 44.8 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлтэй байна.



I.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.3 тэрбум төгрөг буюу 7.3 хувиар буурчээ. Сайн дурын даатгуулагчид 343.4 сая төгрөгийн шимтгэл оруулсан байна. Нийт 8.1 мянган иргэнд 9.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн олгосон байна. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өссөн байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр эхний 3 сард 21.2 мянган иргэнд 2.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэвэрийг 1.2 мянган иргэнд 0.7 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 0.9 мянган иргэнд 0.2 тэрбум төгрөг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 10.7 мянган иргэнд



0.9 тэрбум төгрөгийг, орон нутгийн төсвөөс 0.7 мянган иргэнд 133.8 сая төгрөгийг тус тус олгожээ.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 1-р улирлын байдлаар 62.3 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 6.6 буюу 9.6 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт 16.9 мянган хүн хамрагдсан нь 31.9 хувиар тус тус буурч, 3.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь 2.9 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 5.0 мянган удаа гарсны 1.1 мянга буюу 22.0 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 3.8 хувиар буурч, алсын дуудлага өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

Аймгийн хэмжээнд 321 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 327 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 43 буюу 15.5 хувиар, хүүхдийн тоо 47 буюу 16.8 хувиар тус тус өссөн байна.

Зураг.I.4.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2020 оны эхний 3 сарын байдлаар 140 болж, өмнөх оны мөн үеэс 134 буюу 48.9 хувиар буурахад салхинцэцэг өвчнөөр өвчлөгчдийн тоо 70 хүн буюу 55.6 хувь, тэмбүү өвчнөөр өвчлөгчдийн тоо 47 хүн буюу 64.4 хувь, заг өвчнөөр өвчлөгчдийн тоо 5 хүн буюу 19.2 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.


Нялхсын эндэгдэл энэ оны эхний 3 сарын байдлаар 3 болж, өмнөх оны мөн үеэс 2 хүүхэд буюу 40.0 хувиар буурч, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 болж өмнөх оноосоо 4 дахин өссөн байна.




I.5 Соёл, урлаг:

Хөгжимт жүжгийн театр: 832 үзэгчдэд 2 тоглолтоор үйлчилж 802.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 1.8 мянга буюу 69.2 хувиар буурчээ.

Зураг-I.5.1 Нийт тоглолтын тоо




Зураг-I.5.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Музей: 2.1 мянган үзмэрээр 16 хүнд үйлчилж 62.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 96.7 хувиар буурч, үзмэрийн тоо өмнөх оны түвшинд байна.

Зураг-I.5.3 Нийт үзмэр болон үзэгчдийн тоо, мянган дүнгээр




Номын сан: Нийт 47.1 мянган номоор 0.9 мянган уншигчдад үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс номын тоо 0.3 мянгаар өсч, уншигчдын тоо 0.8 мянгаар буурсан байна.

Зураг-I.5.5 Нийт номын тоо, мянган ш



Зураг-I.5.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн






I.6 Газар өмчлөл:


Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 11.2 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 10.4 мянган иргэнд 938.08 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

Эхний 3 сард аж ахуйн зориулалтаар газар өмчлөхийг хүссэн 25 иргэний өргөдөл ирсэнийг 100 хувь шийдвэрлэжээ.

Зураг I.7.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.7.2 Засаг даргын гаргасан иргэдийн тоо



I.7 Гэмт хэрэг

Аймгийн цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 3 сард 139 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 31 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос 2.2 хувиар өссөн байна.


Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 1.2 тэрбум төгрөгийн хохирол учирсны 86.8 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэрэгт 112 хүн холбогдон сэжиглэгдсэний 34.8 хувь нь согтуугаар, 33.0 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ.

Нийт 175 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 20 хүн буюу 12.9 хувиар өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 25 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 55.8 хувьтай байна.



Зураг I.7.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, банк, даатгал

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3 дугаар сард 130.1 тэрбум төгрөг болж, оны эхнээс 15.1 (10.3%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 9.1 (6.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан.

Банкуудад хадгалуулсан төгрөгийн хадгаламжийн хэмжээ 88.6 тэрбум төгрөг болж, оны эхнээс 2.7 (2.9%) тэрбум төгрөгөөр буурсан ба өмнөх оны мөн үеэс 6.6 (8.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг.II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хугацаа хэтэрсэн чанаргүй зээл, хадгаламжийн үлдэгдэл, сарын эцэст, тэрбум төг



Чанаргүй зээл 3 дугаар сарын эцэст 1.3 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.


Даатгал: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 41.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар өсчээ.

Эхний 1 дүгээр улирлын байдлаар 139 хүнд 21.5 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна. Нөхөн олговрыг төрлөөр нь авч үзвэл авто тээврийн хэрэгсэлд 3.9 сая, жолоочийн хариуцлагын даатгалд 14.2 сая, иргэдийн эд хөрөнгө, гэнэтийн



ослын даатгалд 0.9 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 2.4 сая, төгрөгийг тус тус олгожээ.

Зураг. II.1.2 Даатгалын төрлөөр




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 3 сард 16.6 тэрбум төгрөг болж 18.3 хувиар буюу өмнөх оны мөн үеэс 2.6 тэрбум төгрөг, аймгийн төсвийн нийт зарлага санхүүжилт 14.8 тэрбум төгрөг болж 11.2 хувиар буюу өмнөх оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна

Аймгийн нийт төсвийн 13.4 хувийг орон нутгийн төсвийн орлого, 22.7 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 47.9 хувийг улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг, 1.8 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 4.7 хувийг урьд оны үлдэгдэл, 9.5 хувийг бусад орлогууд эзэлж байна.

Зураг. II.2 Төсвийн орлого, зарлага, тэрбум






II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 4.8 хувь, жилийн эцсээс 1.4 хувиар өслөө.

Зураг.II.3 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хүснэгт.II.3.1 Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 3 дугаар сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2020.III}{2019.III}$	$\frac{2020.III}{2019.XII}$	$\frac{2020.III}{2020.II}$
Ерөнхий индекс	104.8	101.4	100.4
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	107.8	104.4	101.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.6	100.6	100.0
Хувцас, бөс бараа, гутал	103.0	100.5	100.1
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	106.1	100.6	100.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.7	100.6	100.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	101.9	100.0	100.0
Тээвэр	102.4	100.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	101.7	100.5	100.3
Боловсролын үйлчилгээ	110.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	115.2	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	108.4	102.6	100.0

Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.1 хувь, орон сууц, ус, цахилгаан хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 0.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа 0.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



II.4 Хөдөө аж ахуй

Мал төллөлт төл бойжилт. Оны эхний төллөх насны хээлтэгч малын 18.7 хувь буюу 322.9 мянган хээлтэгч мал төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 22.7 хувь, эм ямаа 16.5 хувь, үнээ 9.5 хувь, ингэ 10.2 хувь, гүү 6.0 хувь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 99.5 хувь болох 321.1 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 95.9 мянга буюу 42.6 хувиар өссөн байна.

3 дугаар сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: хурга 99.6 хувь, ишиг 99.3 хувь, унага 97.5 хувь, тугал 98.5 хувь, ботго 99.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс унага, ишиг, тугал, хурга 0.1-1.3 пунктээр буурсан байна.

Зураг-II.4.1 Төллөсөн хээлтэгчийн тоо, сумаар, мян.толгой, 2020 оны эхний 3 дугаар сарын байдлаар



Зураг-II.4.2 Бойжуулсан төлийн тоо, сумдаар, мян.толгой, 2020 оны эхний 3 дугаар сарын байдлаар




Малын онд оролт: Том малын зүй бус хорогдол эхний 3 сарын байдлаар 15.0 мянган толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 11.8 мянган толгой буюу 4.6 дахин өссөн байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 5, адуу 524, үхэр 1.4 мянга, хонь 6.4 мянга, ямаа 6.8 мянган толгой байна.

Малын нийт хорогдлын 45.0 хувийг ямаа эзэлж байна.



Зураг-II.4.3 Том малын зүй бусын хорогдол



Эхний 3 сарын байдлаар оны эхний малын 0.4 хувь нь хорогджээ. Нийт хорогдлын 0.7 хувь буюу 103 толгой мал нь өвчнөөр хорогдсон байна. Өмнөх оны мөн үеэс 20.6 дахин өсчээ.



II.5 АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 10.1 тэрбум төгрөг болж өмнөх оноос 1.1 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 1.4 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар буурсан байна.

Оны үнээр 33.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 49.7 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, дулаан, түгээсэн цэвэр ус, цахилгаан, бууз, банш, бялуу, нарийн боов, талх, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, хэвийн боов, хэрчсэн гурил, дээлнээс бусад монгол хувцас, монгол дээл, сувагжуулалт зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2018	2019	2020	Зөрүү	$\frac{2020}{2019}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	312	280	327	47	116.8
Нялхасын эндэгдэл	хүн	4	5	3	- 2	60.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	1 036	665	687	22	103.3
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	204	274	140	- 134	51.1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	89	136	139	3	102.2
Хэрэгт холбогсод	хүн	44	55	112	57	203.6
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар						
Иргэдийн хадгаламж	хувь	102.7	101.9	101.4	- 0.5	99.5
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	59 159.5	82 013.2	88 630.0	6 616.8	108.1
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	119 800.3	139 232.8	130 117.7	-9 115.1	93.5
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	16 694.4	14 047.8	16 609.8	2 562.0	118.2
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	11 924.6	13 216.6	14 847.3	1 630.7	112.3
Төлөлсөн хээлтэгч	тол	191 466	225 013	322 888	97 875	143.5
-Ингэ	тол	236	179	321	142	143.5
-Гүү	тол	5 741	1 744	6 316	4 572	179.3
-Үнээ	тол	7 984	4 341	10 049	5 708	362.2
-Эм хонь	тол	115 182	141 541	211 134	69 593	231.5
-Эм ямаа	тол	62 323	77 209	95 068	17 859	149.2
Бойжуулсан төл	тол	192 380	225 178	321 146	95 968	142.6
-Ботго	тол	236	177	319	142	180.2
-Унага	тол	5 668	1 723	6 159	4 436	357.5
-Тугал	тол	7 862	4 285	9 893	5 608	230.9
-Хурга	тол	115 706	141 670	210 358	68 688	148.5
-Ишиг	тол	62 908	77 323	94 417	17 094	122.1
Том малын зүй бусын хорогдол	тол	33 139	3 234	15 034	11 800	464.9
- Тэмээ	тол	4	5	5	0	100.0
- Адуу	тол	1 505	232	524	292	225.9
- Үхэр	тол	3 388	161	1 383	1 222	859.0
- Хонь	тол	13 474	1 508	6 351	4 843	421.2
- Ямаа	тол	14 768	1 328	6 771	5 443	509.9
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	90	5	103	98	2060.0
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	-	4	1	-	-
- Үхэр	тол	47	1	3	2	300.0
- Хонь	тол	40	-	46	-	-
- Ямаа	тол	3	-	53	-	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	13 918.7	11 213.9	10 068.1	-1 145.8	89.8
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	79 911.1	83 598.1	33 907.9	-49 690.2	40.6



I.1 ХӨДӨЛМӨР

I.1.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, СУМААР

Сум	2018		2019		2020	2020.III 2019.III %
	III	XII	III	XII	III	
Асгат	15	24	4	15	6	150.0
Баяндэлгэр	52	37	41	36	39	95.1
Дарьганга	38	29	31	46	46	148.4
Мөнххаан	75	64	31	48	65	2.1*
Наран	53	23	29	40	40	137.9
Онгон	69	53	30	16	32	106.7
Сүхбаатар	57	92	62	65	68	109.7
Түвшинширээ	41	72	56	50	60	107.1
Түмэнцогт	45	23	56	29	44	78.6
Уулбаян	62	34	57	100	83	145.6
Халзан	31	13	39	12	23	59.0
Эрдэнэцагаан	156	17	100	35	39	39.0
Баруун-Урт	342	166	129	138	142	110.1
Дүн	1 036	647	665	630	687	103.3

I.1.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, СУМААР, БОЛОВСРОЛ, НАСНЫ БҮЛГЭЭР

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр							Насны бүлгээр						
			Магистр, доктор	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	6	3	-	1	-	-	3	2	-	-	1	-	2	2	1	-
Баяндэлгэр	39	23	-	10	2	4	15	6	1	1	9	14	10	6	-	-
Дарьганга	46	22	-	11	-	12	10	12	-	1	8	19	12	6	1	-
Мөнххаан	65	33	-	7	3	2	42	5	4	2	7	16	22	16	3	1
Наран	40	23	-	9	6	5	12	8	-	-	11	16	7	4	2	-
Онгон	32	15	-	5	-	-	22	4	1	-	4	11	11	5	1	-
Сүхбаатар	68	34	-	10	-	5	41	9	2	1	17	26	16	7	2	-
Түвшинширээ	60	26	-	11	1	5	13	20	9	1	16	22	16	6	-	-
Түмэнцогт	44	22	-	4	1	2	30	2	2	3	4	12	18	10	-	-
Уулбаян	83	47	-	7	1	2	38	17	9	9	13	32	19	10	7	2
Халзан	23	12	-	-	1	1	16	5	-	-	7	6	4	4	2	-
Эрдэнэцагаан	39	12	-	2	1	1	33	1	1	-	9	10	12	8	-	-
Баруун-Урт	142	58	-	27	5	10	78	15	5	2	18	56	39	26	2	1
Дүн	687	330	-	104	21	49	353	106	34	20	124	240	188	110	21	4



I.1.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2018		2019		2020	2020.I-III 2019.I-III %
	I-III	I-XII	I-III	I-XII	I-III	
Асгат	23	175	6	92	7	116.7
Баяндэлгэр	13	117	55	132	75	136.4
Дарьганга	30	123	28	120	3	10.7
Мөнххаан	44	239	14	137	44	3.1*
Наран	51	153	48	157	9	18.8
Онгон	57	218	21	52	21	100.0
Сүхбаатар	7	154	5	162	21	4.2*
Түвшинширээ	18	241	26	177	26	100.0
Түмэнцогт	42	199	52	162	37	71.2
Уулбаян	12	58	32	312	45	140.6
Халзан	32	120	49	101	16	32.7
Эрдэнэцагаан	8	92	97	169	36	37.1
Баруун-Урт	365	1 341	200	990	130	65.0
Дүн	702	3 230	633	2 763	470	74.2

I.1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2018		2019		2020	2020.I-III 2019.I-III %
	I-III	I-XII	I-III	I-XII	I-III	
Асгат	-	71	4	53	3	75.0
Баяндэлгэр	-	39	11	20	28	2.5*
Дарьганга	1	57	-	19	3	-
Мөнххаан	-	98	1	33	8	8.0*
Наран	2	87	24	84	5	20.8
Онгон	-	70	3	5	-	-
Сүхбаатар	-	41	1	109	11	11.0*
Түвшинширээ	9	113	4	90	3	75.0
Түмэнцогт	5	40	1	30	1	100.0
Уулбаян	1	8	8	64	36	4.5*
Халзан	2	41	3	32	4	133.3
Эрдэнэцагаан	4	22	1	11	1	100.0
Баруун-Урт	16	251	20	252	6	30.0
Дүн	40	938	81	802	109	134.6



I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо			Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар										
				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	
	2019. I-III	2020. I-III												
		Байнгын	Түр											
Асгат	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баяндэлгэр	1	12	-	-	-	5	-	4	3	-	-	-	-	-
Дарьганга	1	3	-	-	-	2	-	-	1	-	-	-	-	-
Мөнххаан	-	6	-	-	-	-	-	-	-	6	-	-	-	-
Наран	2	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Онгон	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	3	11	-	-	-	-	4	-	2	3	-	1	1	-
Түмэнцогт	6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	8	19	-	-	1	-	1	-	-	12	3	2	-	-
Халзан	1	4	-	2	-	-	2	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	31	11	-	-	-	-	3	-	-	8	-	-	-	-
Дүн	56	67	-	2	1	7	10	4	6	30	3	3	1	-

**I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				Сайн дурын даатгал шимтгэлийн орлого			
	2019.I-III	2020.I-III			2019.I-III	2020.I-III		
		Төл	Гүйц	%		Төл	Гүйц	%
Асгат	63.1	50.4	65.1	129.2	10.2	20.4	10.7	52.5
Баяндэлгэр	174.0	106.4	128.6	120.9	34.6	40.7	32.6	80.1
Дарьганга	118.9	72.8	87.2	119.8	22.1	30.3	21.5	71.0
Мөнххаан	155.3	99.0	107.5	108.6	31.9	39.7	28.1	70.8
Наран	67.9	43.7	55.1	126.1	14.9	21.7	14.3	65.9
Онгон	192.7	138.7	167.4	120.7	21.3	29.3	20.9	71.3
Сүхбаатар	112.3	77.4	84.2	108.8	20.0	24.0	19.9	82.9
Түвшинширээ	99.0	66.8	93.1	139.4	14.5	20.9	14.1	67.5
Түмэнцогт	83.7	119.4	132.7	111.1	18.1	20.2	17.9	88.6
Уулбаян	130.0	103.7	115.6	111.5	19.2	22.6	13.2	58.4
Халзан	72.6	49.7	68.5	137.8	8.3	11.3	7.5	66.4
Эрдэнэцагаан	290.5	192.6	227.5	118.1	45.0	60.4	37.4	61.9
Баруун Урт	2 582.4	1 942.8	2 456.8	126.5	108.2	217.4	105.3	48.4
Дүн	4 142.4	3 063.4	3 789.3	123.7	368.3	558.9	343.4	61.4

I.2.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

Сум	Тэтгэвэр авагчдын тоо				Олгосон тэтгэвэр, сая.төг			
	2018.I-III	2019.I-III	2020.I-III	%	2018.I-III	2019.I-III	2020.I-III	%
Асгат	249	255	283	111.0	204.6	126.8	289.9	228.6
Баяндэлгэр	586	613	624	101.8	493.5	580.9	697.1	120.0
Дарьганга	335	357	370	103.6	277.1	332.6	396.2	119.1
Мөнххаан	495	514	529	102.9	407.9	476.3	551.8	115.9
Наран	202	205	194	94.6	167.3	198.2	237.6	119.9
Онгон	477	493	511	103.7	448.0	508.8	588.7	115.7
Сүхбаатар	365	376	388	103.2	294.7	343.2	403.2	117.5
Түвшинширээ	362	377	392	102.9	291.7	341.4	401.4	117.6
Түмэнцогт	356	350	371	112.0	299.8	330.6	393.2	118.9
Уулбаян	368	383	396	96.9	303.4	360.6	424.5	117.7
Халзан	191	195	204	104.6	157.9	182.8	213.5	116.8
Эрдэнэцагаан	748	765	782	102.2	641.7	771.5	916.4	118.8
Баруун Урт	2 912	3 024	3 086	102.1	2 699.2	3 112.2	3 604.9	115.8
Дүн	7 646	7 907	8 130	102.8	6 686.8	7 665.9	9 118.4	118.9



I.2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2018.I-III		2019.I-III		2020.I-III	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Улсын төсөвөөс	1 Халамжийн тэтгэвэр	1 132	424.6	1 175	559.4	1 215	655.0
	2 Халамжийн тэтгэмж	1 640	255.7	1 488	297.6	1 605	378.4
	1. Асаргааны тэтгэмж	899	151.5	900	183.4	981	250.9
	байнгын асаргаа шаардлагатай Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	498	82.0	482	95.5	537	125.8
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	148	24.9	206	43.4	210	48.4
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	205	36.1	168	33.9	189	65.5
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	16	3.0	16	3.3	15	3.1
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	9	2.2	10	3.3	10	3.3
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	23	3.3	18	4.0	20	4.8
	3 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	6 806	146.1	7 181	229.6	6 204	229.0
	4 тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	224	37.3	2 636	68.0	235	45.2
	5 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	13	6.1	14	4.8	15	7.2
	6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	283	37.4	326	35.0	299	38.0
	7 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	3 906	442.9	4 134	516.7	4 018	575.9
	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	2 990	357.4	3 268	425.8	3 195	449.0
Жирэмсэн эхийн тэтгэмж	865	69.9	780	60.4	704	65.2	
Ихэр хүүхдийн тэтгэмж	6	12	2	4.0	8	16.0	
3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	45	3.6	84	26.5	111	45.7	
8 Насны хишиг	2 201	185.2	2 366	195.2	2 494	202.2	
9 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	4 734	657.5	4 889	671.9	5 079	673.8	
Орон нутгийн төсвөөс	1 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	741	104.2	588	114.2	624	127.5
	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	148	55.4	167	75.7	428	26.2
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн	584	38.0	410	25.3	190	94.1
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	3.6	2	2.4	2	2.4
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	5	6.0	5	6.0	2	2.4
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	1.2	4	4.8	2	2.4
	2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-	-	1	0.5	94	6.3
	ДҮН	20 939	2 192.8	24 209	2 578.2	21 164	2 804.7

**I.3 ЭРҮҮЛ МЭНД****I.3.1 ЭРҮҮЛ МЭНД**

	Хэмжих нэгж	2019.I-III	2020.I-III	Өсөлт	
				тоо	хувь
1. Нийт үзлэг	мян.хүн	68.9	62.3	-6.6	90.4
2. Ор хоног	мян.хүн	29.3	29.4	0.1	100.3
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	24.8	16.9	-7.9	68.1
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	3.5	3.6	0.1	102.9
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	5.2	5	-0.2	96.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.1	1.1	-	100.0
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	71	74	3	104.2
7. Нийт нас баралт	хүн	87	103	16	118.4
8. Амаржсан эх	хүн	278	321	43	115.5
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	280	327	47	116.8
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	5	3	-2	60.0
10. 1-5 хүртлэх насны эндсэн хүүхэд	хүн	-	4	-	-

I.3.2. ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	-	-	-	-
Баяндэлгэр	4	4	-	-
Дарьганга	2	3	1	-
Мөнххаан	-	-	-	-
Наран	2	2	-	-
Онгон	4	4	-	-
Сүхбаатар	-	-	-	1
Түвшинширээ	-	-	-	-
Түмэнцогт	1	1	-	-
Уулбаян	-	-	-	-
Халзан	-	-	-	-
Эрдэнэцагаан	9	9	-	2
Баруун-Урт	299	304	2	1
Дүн	321	327	3	4



I.3.3. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, сумаар

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2019.I-III	2020.I-III	Өсөлт	
				тоо	хувь
Вируст гепатит	хүн	1	-	-	-
